


АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЧИГ БАРИМЖАА ОЛГОХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ, ХӨДӨЛМӨР ЗУУЧЛАЛ

Бид 2013 оны 7 дугаар сараас эхлэн хөдөлмөрийн хувийн биржийг тогтвортой ажиллуулж эхэлсэн ба ажил хайгч иргэн, ажил олгогч, ажлын байрыг бүртгэх, мэдээлэл өгөх, ажилд зуучлах, мэдээллийг хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн мэдээллийн санд нэгтгэх, ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт зохион байгуулах, зөвлөгөө өгөх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.




*Мэдрэмжтэй байх нь
Мэдлэгтэй байхаас ч илүү.*
АЛЬБЕРТ ЭЙНШТЭЙН

“ХҮНИЙ ХӨГЖИЛ СУДАЛГАА СУРГАЛТЫН ТӨВ” ТББ-ЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



“ХҮНИЙ ХӨГЖИЛ СУДАЛГАА СУРГАЛТЫН ТӨВ” ТББ



🏠 СБД, 9-р хороо,
17/1-р байр 202

✉ info@human-development.mn

ХХССТ

ХХССТ

Хүний хөгжил судалгаа сургалтын төв нь 2004 оноос эхлэн Олон улсын болон төрийн байгууллага, бизнесийн байгууллагуудын захиалгаар макро болон микро түвшиний судалгаа, шинжилгээний ажил, төсөл хөтөлбөрийн үнэлгээ, мониторинг, жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулсан бизнесийн сургалтууд, худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалт, хөдөлмөр зуучлал зэрэг зөвлөх үйлчилгээнүүдийг үзүүлсээр ирсэн.




ЗОРИЛГО: Хүн амын хөгжлийг хангах, ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэх, бизнесийн хөгжлийг дэмжих чиглэлээр судалгаа хийх, сургалт явуулах, ажилд зуучлах, ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх үйлчилгээ үзүүлэх, оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд чиглэсэн хүмүүнлэгийн үйл ажиллагааг зохион байгуулах.

БИДНИЙ ЗАРЧИМ:

1. Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж
2. Үнэнч шударга, ёс зүйтэй байдал
3. Харилцан бие биеээсээ суралцсан хамтач үйл ажиллагаа
4. Харилцан бие биенээ хүндэтгэсэн найрсаг харилцаа

БИДНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА
Судалгаа, Үнэлгээ, Мониторинг:



Судалгааны нэгж нь зөвлөх, үндсэн болон гэрээт судлаачид, мэдээлэл цуглуулах баг, мэдээллийн системийн баг болон тоологчид, хяналтын баг гэсэн бүтэцтэйгээр ажилладаг.

Судалгааны ажлын захиалгаас хамаарч төслийн хэд хэдэн багийг бүрдүүлж ажиллах боломжтой бөгөөд төсөл тус бүрт судалгааны менежер буюу Төслийн ахлагчийг томилж, Гүйцэтгэх захирал ерөнхий удирдлагаар хангаж ажилладаг.

Бид захиалагчийн онцлогт нийцүүлэн эдийн засаг, нийгэм, улс төрийн судалгааг дэвшилтэт технологийг ашиглан олон улсын арга, аргачлалын дагуу хийдэг.



ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ МЭРГЭШСЭН АЖИЛТАН БЭЛТГЭХ СУРГАЛТ

Засгийн газрын худалдан авах ажиллагааны тогтолцоог илүү тод, үр ашигтай болгох, худалдан авах ажиллагааны бодлого түүний хэрэгжилтэд иргэний нийгэм, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх АЗ” сургалтыг Сангийн яамны албан ёсны эрхтэйгээр зохион байгуулж байна. Мөн тендерт оролцож буй байгууллагуудад тендерийн материал хэрхэн бэлтгэх талаар зөвлөгөө, мэдээлэл өгдөг.



ЖИЖИГ, ДУНД БИЗНЕС ЭРХЛЭГЧДЭД ЗОРИУЛСАН СУРГАЛТ

Тус сургалтыг 2012 оноос эхлэн Хөдөлмөрийн яамны харьяа Хөдөлмөр халамж, үйлчилгээний ерөнхий газрын сургалт явуулах тусгай зөвшөөрөл авч, ажил олгогч байгууллагын захиалгат болон ажилгүй иргэдэд аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулах, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах зөвлөх үйлчилгээг үзүүлдэг.

